



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2017 оны 10 сарын 05 өдөр

Дугаар Б/44

Улаанбаатар хот

Албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4, Усны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.11, Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Рэнчинсамбуугийн Одонбаатарын өөрийн гаргасан хүсэлтийг үндэслэн тус яамны харъяа Хөвсгөл аймгийн Мөрөн суманд байрлах "Хөвсгөл нуур-Эгийн голын сав газрын захиргаа"-ны даргын албан тушаалаас 2017 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөр дуусгавар болгон чөлөөлсүгэй.

2.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Р.Одонбаатард 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэлэг болох 2 387 805 /Хоёр сая гурван зуун наян долоон мянга найман зуун тав/ төгрөгийн нөхөн олговрыг тооцож олгохыг Санхүүгийн хэлтсийн дарга Б.Нансалмаа, яамны төсвийн ерөнхий нягтлан бодогч Д.Гүндсамбуу нарт тус тус зөвшөөрсүгэй.

3.Р.Одонбаатарын ажил үүрэгтэй холбогдох баримт бичиг /файл/ болон эд хөрөнгө, техник, тоног төхөөрөмжийн тооцоог хийж ажил хүлээлцүүлэхийг Төрийн захиргааны газрын дарга Х.Батжаргал, Сав газрын удирдлагын хэлтсийн дарга Н.Баттулга, Санхүүгийн хэлтсийн дарга Б.Нансалмаа, тус Сав газрын захиргааны нягтлан бодогч нарт тус тус үүрэг болгосугай.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ОЮУНХОРОЛ